


НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Гялалзахын хөндий” ХХК-ийн хэрэгжүүлж буй аялал жуулчлалын бааз төсөл нь Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Өвөр горхид 5.0 га талбайд байрлана. Төслийн талбайд одоогоор 8 ширхэг гэр, 15 ширхэг байшин, рестораны барилга байна. Нэмэлтээр гурван давхар буудлын барилга, зогсоолын талбай, спорт тоглоомын талбай, сүүдрэвч, саравч бүхий дүүжин сандал, вандан сандал, ногоон байгууламж, гараж, харуулын байр, бохирын цооног зэргийг төлөвлөөд байна.

Хүснэгт №1 Төслийн талбайн координат

№	Геодезийн солбилцол		Талбайн хэмжээ, га
1	107° 25' 14.384"	47° 53' 42.139"	5.0 га
2	107° 25' 13.760"	47° 53' 41.325"	
3	107° 25' 10.460"	47° 53' 42.165"	
4	107° 25' 11.976"	47° 53' 43.095"	
5	107° 25' 9.134"	47° 53' 44.885"	
6	107° 25' 8.946"	47° 53' 46.311"	
7	107° 25' 16.719"	47° 53' 49.576"	
8	107° 25' 19.581"	47° 53' 49.738"	
9	107° 25' 24.917"	47° 53' 51.545"	
10	107° 25' 26.186"	47° 53' 49.256"	
11	107° 25' 25.961"	47° 53' 46.072"	
12	107° 25' 24.507"	47° 53' 45.503"	
13	107° 25' 20.116"	47° 53' 46.453"	
14	107° 25' 15.047"	47° 53' 44.331"	

Зураг №1 Төслийн талбайн байршил



**ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Уур амьсгал	Хан Хэнтийн ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нь тэгш хэмийн хуваарьлалттай. Хаврын дулааралт, намрын сэрүүсэлтийн явц нь ижилхэн, зун нь сэрүүн чийглэг, өвөл нь хүйтэн чийглэг, уур амьсгалын үзүүлэлт нь хэм тэнцүү хуваарилалттай байдаг. Хавар нь хуурайвтар, хахир хахирлаг, намар сэрүүн сэрүүвтэр, үе үе хөрөлтийн буюу цацрагийн манан хүдэн татаж байдаг. Зун нь урт биш, төдий л халуун биш байдаг. Монгол орны бусад нутгаас хамгийн их хур тунадастай, чийглэг, сэрүүн өвөл нь цасархаг харьцангуй дулаавтар тунгалаг цэнгэг агаартай (Намхайжанцан, 1994).
2	Газрын гадарга	Горхи-Тэрэлжийн БЦГ нь сибирийн геоморфологийн их мужийн Хангай-Хэнтийн уулст өндөрлөг мужийн хэнтийн төвийн дэд мужийн хэнтийн захын тойрогт багтана. Горхи-Тэрэлжийн БЦГ нь геологийн тогтоцын хувьд мезозойн настай боржин, гранидиорит, лейкоборжин, гранимент, шүлтлэг боржин, девоны доод үеийн шаварлаг занар, хас, нүүрст ба нүүрстөрөгчит шаварлаг занар, аргеллит, алевролит, элсэн чулуу зэрэг хурдас чулуулаг уул нуруудаар, туул болон бусад голуудын хөндийд дөрөвдөгчийн хурдас тархсан. Горхийн районд далайн түвшнээс дээш 1848.1-2077.1 м өргөгдсөн Орог ямаат, Номт, Оргих, Их бах, Мөст, Ёлын цохио, Чингэс уул, тэдгээрийн хоорондох нарийн ам хөндийнүүд, шижрэх, ар, өвөр горхи, улиастай, өлийн булан, өгөөмөрийн амнаас тогтоно.
3	Хөрсөн бүрхэвч	Горхи-Тэрэлжийн БЦГ нь монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар хангайн хөрс-био уур амьсгалын их мужийн чийглэг өндөршлийн бүсшил бүхий төв хэнтийн тойргийн өмнөт хэсэгт, Хан Хэнтийн дархан газрын Туул-Тэрэлжийн бэлчирээс урагших дундаж өндөрлөг уулсаар хүрээлэгдсэн ар горхи, өвөр горхийн амыг бүхэлд нь эзэлж орших учир ууланднь уулын ширэгт-тайгын хөрс, уулын ойн бараан ба уулын хар шороон хөрс, урсгал устай, усгүй ам хөндийгөөр нь хар шороон, нугат-хар шороон хөрс, нугын ба нугат-намгийн цэвдэгт хөрс, аллювийн хөрс зэрэг 8 үндсэн хэв шинжид хамрагдах хөрс, тэдгээрийн төрлүүд тогтворжино.
4	Ургамлан нөмрөг	Энэ мужлалд 27 овогт багтах 87 зүйлийн дээд ургамал багтах аас гадна 3 зүйлийн хөвд арвин ургаж байна. Эдгээрээс тэжээлийн 36 зүйл, эмийн 14 зүйл, хүнсний 8 зүйл, чимэглэлийн 6 зүйл, ус зохицуулах 16 зүйлийн ургамалтай болохыг судлаачид тогтоосон байна. Торлогт бүлгэмдэл нь Хэнтийн нурууны хувьд нилээд тархсан, хур борооны усыг биедээ татаж усыг жигд тогтвортой хуваарилдаг, голын хөндийн цэвдгийг хамгаалж, халхалж байдаг, ан амьтан жижиг шувуудын орогнон амьдрах нэгэн гол газар болдог. Дэд зонхилогчид: Намгийн-Аулякомум (хөвд), Шмидтийн улалж зэрэг ургамал байна.
5	Гадаргын ус	Төсөл хэрэгжих газрын ойр орчимд нь томоохон голын урсац, нуур, булаг шандын эх байхгүй болно. Харин төсөл хэрэгжих район болох Горхи-Тэрэлжийн БЦГ газарт урсах томоохон гол

№	Үзүүлэлтүүд	Утга
		<p>нь Тэрэлж гол байдаг. Хэдийгээр Тэрэлж гол нь төсөл хэрэгжих газраас хол орших боловч тус голын ай савд төсөл хэрэгжихийг тооцон авч үзэх нь зүйтэй.Тэрэлж гол Хэнтийн нурууны ноён оргил Асралт хайрхан уулын баруун урд суганаас эх авч 70 км урсаад Туулын голд цутгадаг. Зүүн уртрагийн 107°34', хойд өргөрөгийн 47°57'-д оршдог Тэрэлж голын хөндий нь өргөн, модтой, ус намаг ихтэй байдаг нь түүний эртний мөстлөг уул хөндийн шинжтэй байсныг илтгэнэ (Цэгмид, 1948).</p>
6	Гүний ус	<p>Тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцөлийг илэрхийлж буй газрын доорхи усны тархалт, бүрэлдэн тогтолтын ерөнхий байдал болон геологийн тогтоцын өвөрмөц онцлогыг үндэслэн, судалгааны дэвсгэр талбайн хүрээнд гидрогеологийн давхарга зүйн хувьд дараах биеэ даасан уст үе давхарга, газрын доорхи усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна. Аллювийн гарал үүсэлтэй орчин үеийн сэвсгэр хурдасны зузаалаг дахь уст үе давхарга. Доод-дунд девоны настай бялхмал-тунамал чулуулгийн массив дахь алаг цоог тархалттай газрын доорх ус.</p>
7	Амьтан	<p>Төсөл хэрэгжих орчны эргэн тойрны нутаг хөхтөн амьтнаар баян юм. Бидний хийсэн судалгаагаар энд монгол орны хөхтөн амьтны зүйлийн бүрэлдэхүүний 59,7 %-тай тэнцэх 6 багийн 43 зүйл амьтан байнга юмуу түр нутагладаг. Хөхтөн амьтны бүртгэлийг гаргахдаа тухайн орчинд бидэнд биеэр олдож үзэгдээгүй ч ул мөр нь байгаа, хил залгаа байгалийн ижил нөхцөлтэй газарт байдаг болох нь нотлогдсон, энд байх бүрэн үндэслэлтэй амьтдыг оруулав. Хөхтний бүрэлдэхүүнийг баг тус бүрээр нь авч үзвэл шавж идэштэн 5 зүйл (эндэхийн хөхтөн амьтны 11,6%), сарьсан далавчтан 5 зүйл (11,6%), туулай хэлбэртэн 3 зүйл (7%) мэрэгчтэн 16 зүйл (37,2%), мах идэштэн 9 зүйл (21%), туруутан 5 зүйл (11,6%) байна.</p>

**ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ
ТОДОРХОЙЛОЛТ**

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Агаар орчин	Төслөөс агаар орчинд нөлөөлөх байдал нь тэврийн хэрэгслээс гарах дотоод шаталтын хийнүүд болон хатуу, шингэн хог хаягдлаас үүсэх бохирдол, мөн барилгын суурь цутгах үед хөрс хуулах явцад үүсэх тоосжилт зэрэг болно.
2	Хөрсөн газрын хэвлий бүрхэвч, гадарга,	<p>Энэхүү төслийг нийт 5.0 га талбайд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаа бөгөөд уг төсөл хэрэгжих талбай болон ойр орчмын газар нөлөөлөлд өртөхөөр байна. Орчны тохижилт, ургамалжуулалт хийдэггүйгээс талхлагдал, хуурайшил, цөлжилтийн үйл явц ажиглагдах бөгөөд энэ тал дээр дорвитой арга хэмжээ авах шаардлагатай. Барилгын болон ахуйн хог хаягдлыг эмх цэгцгүй хадгалж, хаяснаас орчны гадаргуу өнгө үзэмжээ алдан доройтолд хүргэх зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэхээр байна.</p> <p>Мөн төслийн талбай орчмын газрын хөрс баазын барилгын үе шатанд машин техникийн нөлөөгөөр талхлагдах, эвдрэх, амрагчдын байр болон орчны бүсүүдэд хөрс ахуйн хатуу хог хаягдал болон органик бодисоор бохирдох, авто машины зогсоол, түүний орчим тээврийн хэрэгслээс шатахууны асгаралт, шүүрэлт, дусагнах байдал үүсэж хөрс тос, тосолгооны материалаар бохирдож болзошгүй юм.</p>
3	Усны нөөц, чанар	Хэрвээ газрын доорх усан орчин бохирдсон тохиолдолд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлөх эрсдэл бий. Мөн хүн, ургамал, мал амьтан, газрын доорх усны хэрэглээг хэт нэмэгдүүлснээс газрын доорх усны нөөц хомсдох, химийн бодис, урвалж агуулах боломжтой бохир ус хөрсөнд алдаж асгаснаас усан орчин бохирдох зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй юм.
4	Ургамал	Барилга байгууламж барих, олон салаа зам үүсэх зэргээр хөрсний өнгөн хэсгийг хуулах, талхлах улмаар ургамлан бүрхэвчийг устгах, мөн ховор, эмийн ургамлыг түүснээр тухайн ургамал устгах зэрэг эрсдэл байна. Ерөнхийдөө тус төслийн үйл ажиллагаанаас нөлөөллийн бүс орчимд ургамлан нөмрөг бага зэрэг доройтолд орж болзошгүй байна.
5	Амьтан	Тус төсөл хэрэгжих газар нь Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт орших ба амьтны аймгийн төлөөлөгчид ихтэй. Уг төсөл хэрэгжсэнээр авто тээврийн хэрэгсэл, авто ба явган зам харгуй, хүмүүсийн бөөгнөрөл ялангуяа дуу чимээ нь амьтдад сөргөөр нөлөөлж эзэмшил газраасаа дайжихад хүргэж болзошгүй байна. Мөн төслийн барилгын үйл ажиллагаа явуулж байх үед тус газар нутагт амьдардаг амьтны аймагт дам болон шууд байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй. Ялангуяа

№	Үзүүлэлтүүд	Утга
		машин техникийн зорчих хөдөлгөөн, барилгын үед үүсэн бий болох дуу чимээ, газар шорооны ажилтай холбоотойгоор үүсэх тоосжилт зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдаж болзошгүй юм.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Гялалзахын хөндий” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын цогцолбор” төсөл нь Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Өвөр горхид 5.0 га талбайд байрлана. Тус аялал жуулчлалыг цогцолбор нь нэг ээлждээ 220 зочин хүлээн авах хүчин чадалтай.

- ✚ Үйлчилгээний цогцолбор- А, Б блок
- ✚ Ногоон байгууламж
- ✚ Тоглоомын талбай
- ✚ Хатуу хучилттай зам
- ✚ Авто зогсоол зэргийг барихаар төлөвлөөд байна.

“Аялал жуулчлалын цогцолбор” төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын аялал жуулчлал, үйлчилгээний төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах агуулгыг баримтлан боловсрууллаа. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд **3 395 300₮** зарцуулахаар төсөвлөв.

Хоёр. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Тоосжилт үүсэх	Тоосжилтыг бууруулахын тулд тээврийн хэрэгслийн хурдны хязгаарлалт, зам талбай, зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ, анхааруулгыг байршуулах ¹		ширхэг	84 700₮	2	169 400₮	2023 оны 4-р сар	Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596 : 2014
		Явган зам		м ²	Дотоод төлөвлөлтөөр	500	-	2023 оны 4-р сар	
2	Үнэрийн бохирдолт үүсэх	Ил задгай хог хаягдал хаях, шингэн хаягдал асгахаас сэргийлэх	Төслийн талбай	м ²	-	-	-	2023 онд	-
3	Гүний болон гадаргын ус бохирдох	Бохир ус хуримтлуулах сав, дамжуулах хоолойд байнга хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Бохирын цооног орчимд	м ²	-	-	-	2023 онд	БОАЖС, СС-ын хамтарсан 2018 оны А/70/56 тоот тушаал

¹ “Эйч Эс Си Ту” ХХК-ийн НӨАТ орсон дүнгээр тооцлоо.

“Гялалзахын хөндий” ХХК-ийн Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Өвөр горхид хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын бааз”-ын 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
4	Ургамал нөмрөг устгах	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу ногоон байгууламж тарих	Төслийн талбай		Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний дагуу			2023 онд	MNS 6426:2013
Нийт зардал						169 400₮			

Гурав. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг ²	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	<i>“Эдэлбэр газрын нийт талбайн 30%-с доошгүй талбайд ногоон байгууламжтай хөл газрын ургамалгүй байна³ гэсэн шаардлагын дагуу</i>	Төслийн талбайд	Шинэсний 5 настай суулгац	ширхэг	20	50 000₮	1 000 000₮	2023 оны 5-р сар	Аргачилсан зааврын дагуу
			Шар хуайс 4 настай суулгац	ширхэг	30	5 000₮	150 000₮		

² Зах зээлд зарагдаж байгаа дундаж үнээр тооцлоо.

³ ХБТХууль 12.6.3 заалт

“Гялалзахын хөндий” ХХК-ийн Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газрын Өвөр горхид хэрэгжүүлж буй “Аялал жуулчлалын бааз”-ын 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг ²	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
	ногоон байгууламж тарих								
2	Арчилгаа		Усалгаа	м ³	Дотоод төлөвлөлтөөр				
1 150 000₮									

Дөрөв. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай орчимд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

Тав. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Хатуу	Үүссэн хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав байрлуулах	Төслийн талбай	ширхэг	200 000₮	6 /багц/	1 800 000₮	2023 онд	Хог хаягдлын тухай хууль /2017 он/
Нийт зардал					1 800 000₮				

Зургаа. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Хяналтын цэгээс	Зуны улиралд	Жилд 1 удаа	48 400₮	48 400₮	“Ханлаб” ХХК-ийн /НӨАТ/ орсон	MNS 5850:2019
	Хөрсөнд агуулагдах хүнд металлын шинжилгээ				36 800₮	36 800₮		
	Хөрсний агрохимийн шинжилгээ				20 000₮	20 000₮		
2	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Нөөцийн савтай уснаас	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	49 700₮	49 700₮	“Монгол-Ус” ТӨХК-ийн үнийн дүнгээр тооцлоо.	MNS 4943:2011
3	Ундны усны бүрэн шинжилгээ			Жилд 1 удаа	43 000₮	43 000₮		
4	Ундны усан дахь хүнд металлын агууламж			Жилд 1 удаа	78 000₮	78 000₮		
Нийт зардал					275 900₮			

Долоо. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
1	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	-	2023 онд			“Гялалзахын хөндий” ХХК-ийн захирал	-
2	Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Дотоод төлөвлөлтөөр	2023 онд				-
	Нийт	-					

Найм. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	“Гялалзахын хөндий” ХХК	Тайлан	Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	11-р сарын 01-ний дотор	-	Компаний удирдлага, мэргэжилтэнүүд	Улаанбаатар хот
2		Тайлан	Тухайн жилийн БОМТ	12-р сарын 1-ний дотор	-		

Ес. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал, /Төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	169 400₮
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1 150 000₮
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1 800 000₮
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	275 900₮
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
6	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	-
7	Нийт зардал /2023 он/	3 395 300₮